



Монгол цэцэрлэгийн хүүхдүүд Цэцэрлэгийн хүүхдүүдийн хөгжлийн түвшний судалгаа

Bernhard Nagel, Erik Danay

Мюнхены Их Сургууль, Бага насны хүүхдийн хөгжлийн институт

Холбоо барих зохиогч: bernhard.Nagel@extern.lrz-muenchen.de

Хүлээн авсан: 2020.06.03

Хянагдсан: 2020.10.20

Зөвшөөрсөн: 2020.10.30

Хураангуй

Монгол Улсад 2016 онд шинэ сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжсэн. Энэхүү сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нэг хэсэг бол хичээлийн жилд нэг удаа явагддаг цэцэрлэгийн хүүхэд бүрийн хөгжлийн түвшний ажиглалт, ажиглалтын баримтжуулалт байв. Энэхүү ажиглалтыг бүтэцлэгдсэн, стандартчилагдсан ажиглалтын аргачлалыг¹ ашиглан явуулсан. Хүүхдийн хөгжлийн бүтэцлэгдсэн ажиглалтын аргачлал нь ачаалал багатайгаар маш олон тооны хүүхдийн хөгжлийн үнэн зөв, найдвартай өгөгдлийг цуглуулахад тохиромжтой байдаг. Энэ нь боловсролын бодлогын арга хэмжээ ба хүүхдийн хөгжлийн ахиц дэвшил хоёрын уялдаа холбоог судлах чухал урьдач нөхцөлийг бүрдүүлдэг.

2016-2018 онуудад жил бүр санамсаргүй түүврээр 15000 цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн мэдээлэл (хүн амын доторх тухайн насны хүүхдийн бараг 20 хувьтай тэнцэнэ)-ийг авч судаллаа.

Үр дүнгээс харахад 2016-2018 онд хувь хүний хөгжлийн чиглэл бүрээр хүүхдийн хөгжлийн түвшинд мэдэгдэхүйц ахиц гарсан. Гэхдээ хөгжлийн чиглэлүүдийн хооронд ялгаа байсан. Ялгааг хот/хөдөө, улсын/хувийн, интернэтийн сүлжээнд холбогдсон байдал зэрэг шалгуураар авч үзсэн. Аймгууд болон Улаанбаатар хотын дүүргүүдийг харьцуулж үзэхэд тэдгээрийн хооронд тодорхой ялгаанууд харагдсан. Бүтэц:

1. Монголын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр
2. Ажиглалтын хуудас
3. Хөгжлийн судалгаа
4. Үр дүн
5. Дүгнэлт

Түлхүүр үг

¹Хүүхдийн хөгжлийн чиглэлүүдээр бэлтгэсэн ажиглалтын хуудсын дагуу ажиглалт явуулж, үр дүнг нэгтгэн дүгнэдэг.

Бага насны хүүхдийн хөгжлийн ажиглалт, хөгжлийн түвшин, хөгжилд үзүүлэх дэмжлэг, ажиглалтын хуудас, ажиглалтын судалгаа

1. Монголын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр

Монгол Улсад 2016 онд бага насны сурган хүмүүжүүлэх ухааны олон улсын хөгжлийн чиг хандлагад үндэслэсэн, ерөнхий чиглүүлэгүүд бүхий Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжсэн.

Энэхүү сургалтын хөтөлбөр нь 2016 онд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд оруулсан өөрчлөлтэй уялдаатай. Тус хуулийн 3.1 дүгээр зүйлд “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” (Law on Preschool Education, 2016) гэжээ. Энэхүү заалтад Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-ын сургалтын хөтөлбөрийн сурган хүмүүжүүлэх чиглэл болон үзэл баримтлал үндэслэсэн байна.

Үүнээс гадна СӨБ-ын сургалтын хөтөлбөр нь өөр хоёр чухал зарчмыг баримталсан байдаг.

- Хүүхэд бүр адилгүй. Тиймээс хүүхдийн нас тус бүр дээр бус, харин хөгжлийн түвшинд төвлөрсөн.
- Хичээлүүд бус, хөгжлийн чиглэлүүд (Нийгэмшихүй, Хөдөлгөөн ба эрүүл мэнд, Хэл яриа, Байгаль, нийгмийн орчин, Математикийн энгийн төсөөлөл, Хөгжим, дүрслэх урлаг)-ийг тодорхойлсон. Багш ангид явуулах үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах сургалтын агуулга, арга зүй, орчинд тавигдах нийтлэг шаардлагыг заажээ.

Хүүхдийн хөгжилд гэр бүлийн ач холбогдлыг мөн онцолсон байна.

- Хүүхэд үндсэн чадамжууд(competencies)-ыг бүхий л орчин нөхцөлд социал-конструктив (social-constructivist) үйл явцад идэвхтэй оролцсоноор эзэмшинэ гэж үзсэн. Иймд сургалтын хөтөлбөрийг зөвхөн СӨБ-ын байгууллагууд бус, гэр бүл (эцэг эх) мөн хэрэгжүүлнэ. Гэр бүл бол бага насны хүүхдэд тасралтгүй, хүчтэй нөлөөлж байдаг сургалтын чухал орчин.

Сургалтын хөтөлбөрийн гол нь суралцахуйн чиглэлүүд (Children’s learning areas)-ийг тодорхойлсон “цөм хөтөлбөр”-ийн хэсэг. Үүнд:

- Хөдөлгөөн, эрүүл мэнд
- Зан чанар, харилцаа
- Хэл яриа
- Байгаль, нийгмийн орчин
- Математикийн энгийн төсөөлөл
- Хөгжим, дүрслэх урлаг

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн чиглэлүүдийн дагуу цэцэрлэгийн хүүхэд бүрийн хөгжил буюу суралцахуйн ахицыг хөгжлийн 7 чиглэлээр ажиглаж, баримтжуулж ирсэн:

- Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж
- Нийгэмшихүйн чадамж
- Хэл ярианы чадамж
- Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харьцах чадамж
- Математикийн чадамж
- Дүрслэх урлагийн чадамж
- Хөгжмийн чадамж

Хүүхэд бүрийн ажиглалт, баримтжуулалтыг тодорхой бүтэц бүхий ажиглалтын хуудасны тусламжтай явуулсан. Энэхүү нарийвчилсан ажиглалтыг хүүхдийн хөгжлийг харуулсан хувийн хавтас болон чөлөөт ажиглалтаар дэмжиж өгнө.

2. Ажиглалтын хуудас

Монголын СӨБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд нарийвчилсан бүтэцтэй ажиглалтын аргачлалыг боловсруулсан бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрт тодорхойлсон хөгжлийн чиглэлүүдтэй уялдаатай. “Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас” нь туршигдсан, баталгаатай аргачлал бөгөөд ялангуяа германы бага насны сурган хүмүүжүүлэх ухаан (Z.B.KOMPIK, 2014)-ы практикт суурилжээ. Ажиглалтын аргачлал нь гурван үүрэгтэй. Нэгдүгээрт, хүүхэд бүрийн тухайн цаг үе дэх хөгжлийн түвшнийг баримтжуулна, хоёрдугаарт, багшид тухайн хүүхдэд аль хөгжлийн чиглэлээр түлхүү дэмжлэг үзүүлэх шаардлагатай нь мэдэгдэж чиглэл өгнө, гуравдугаарт, хүүхэд бүрийн хөгжлийн явц тэмдэглэгдэн үлдэж баримттай болно.

Боловсруулалт нь олон улсын стандарт, сорилын шалгуурын дагуу хийгдсэн тул уг аргачлалыг шинжлэх ухааны судалгаанд ашиглаж болно.

Ажиглалтын хуудас нь дараах хөгжлийн чиглэлүүдэд хуваагдсан:

1. Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж
 - 1.1 Биеийн хөдөлгөөнөө удирдах
 - 1.2 Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах
 - 1.3 Эрүүл мэндээ хамгаалах
2. Нийгэмшихүйн чадамж
 - 2.1 Зан чанар
 - 2.2 Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, удирдах
 - 2.3 Бусадтай харилцах
3. Хэл ярианы чадамж
 - 3.1 Сонсох, ойлгох
 - 3.2 Ярих
 - 3.3 Унших, бичих бэлтгэл
4. Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж
 - 4.1 Орчноо шинжлэн судлах

- 4.2 Орчинтойгоо харьцах
- 5. Математикийн чадамж
 - 5.1 Тоолох
 - 5.2 Хэмжих
- 6. Дүрслэх урлагийн чадамж
 - 6.1 Зурах
 - 6.2 Урлах
- 7. Хөгжмийн чадамж
 - 7.1 Дуулах, хөгжимдөх
 - 7.2 Бүжиглэх, жүжиглэх

2015 онд 567 хүүхдийн төлөөлөлтэй түүвэр судалгаан дээр ажиглалтын аргачлалын чанарыг шалгасан. Үзүүлэлтүүд сайн байсан нь дараагийн гурван жилд баталгаажсан.

Фактор (хүчин зүйлс)-ын анализын тусламжтайгаар боловсруулалтын үнэн зөв байдал (Construct-validity)-ыг тодорхойлсон. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан чадамжид хамаарах ач холбогдол бүхий долоон хүчин зүйлийг илрүүлэн авч үзсэн.

2018 оны судалгаагаар ажиглалтын хуудас нь *enlightened variance*-аар 82%-тай байсан нь энэ аргачлалын хувьд маш сайн үнэлгээ юм.

Найдвартай байдал (Reliability)-ыг Кронбахс альфа (Cronbach's Alpha)-гаар тодорхойлсон. Үнэлгээ нь 0.9-ээс дээш гарсан тул найдвартай байдал маш сайн.

3. Цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн судалгаа

Боловсролын талаарх олон улсын хэлэлцүүлгээс хүүхдийн хөгжлийг бүүр сургуулийн өмнөх наснаас нь хэрхэн дэмжиж, хөгжилд нь яаж түлхэц үзүүлэх вэ гэдэг асуулт улам чухлаар тавигдаж байна.

Энэ асуултын үндэслэлтэй хариулт бол хүүхдийн хөгжлийн түвшнийг үнэн зөв, найдвартай үнэлэх, түүнчлэн хөгжлийг нь олон жилийн турш үргэлжлүүлэн ажиглахад оршино. Хэдэн жилийн туршид явуулах харьцуулсан судалгаа нь олон удаагийн судалгааны харьцуулалт буюу урт хугацааны судалгаанаас гарч ирнэ. Ажлын ачааллыг бага байлгах үүднээс энэхүү судалгаагаар 2016, 2017, 2018 оны судалгаануудыг харьцуулан авч үзлээ. Энэ судалгаа нь урт хугацааны судалгаа хийх урьдач нөхцөлийг үндсэндээ бүрдүүлсэн гэж үзэж байна.

Хүүхдийн хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулахдаа "*Хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас*"-ыг үндэс болгон ашигласан. Энэхүү ажиглалтын хуудсыг Монгол улсын СӨБ-ын сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд боловсруулсан бөгөөд үүнд сургалтын хөтөлбөр дэх тодорхой хөгжлийн чиглэлүүд тусгалаа олсон. Факторын анализын тусламжтайгаар хүчин зүйлсийн үнэн зөв байдлыг тодорхойлсон. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан чадамжид оноож болох ач холбогдол бүхий долоон хүчин зүйлийг илрүүлэн авч үзсэн. Хүчин зүйлсийн тоог нэг талаас Хорнын параллел анализ (Horn parallel analysis)-ын тусламжтай, нөгөө талаас MAP тест (MAP Test)-ээр тодорхойлсон. Мөн хүчин зүйлсийн харьцуулалт нь энгийн бүтэцтэй байхад анхаарсан. Илрүүлэх

арга (Extraction method)-д “*obliquen oblimin Rotation*”-той “*minres*”-ийг сонгосон бөгөөд энэ нь хөгжлийн чиглэл бүр хоорондоо уялдаатай байсантай холбоотой.

Хэрэгжилт

2016, 2017 ба 2018 онд цэцэрлэгийн хүүхдийн ажиглалтын хуудсаар 3-аас 6 насны хүүхдүүдийг ажигласан. Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо 2016 онд 14.997, 2017 онд 17.717, 2018 онд 17.737 байсан нь монголын хүн амын эдгээр насны хүүхдүүдийн 18 орчим хувийг эзэлнэ.

Ажиглалт нь энэ онуудын эхний хагас жил тутамд явагдсан. Боловсролын үнэлгээний төв судалгааг зохион байгуулж, мэдээллийг төвлөрүүлэн цуглуулсан.

Судалгаа

Хүүхдүүд дээр хийх ажиглалтыг монголын цэцэрлэгүүд дээр тухайн цэцэрлэгийн багш нар явуулж, баримтжуулсан. Үүний өмнө цэцэрлэгийн багш нар улсын хэмжээний мэргэжил дээшлүүлэх сургалтаар СӨБ-ын сургалтын хөтөлбөр болон хүүхдийн хөгжлийн түвшнийг тогтоох ажиглалтын хуудастай танилцсан.

Үнэлгээ

Нэгбүрчилсэн асуулт буюу ажиглалтын үр дүнг хүчин зүйлсэд харгалзуулан Хэлний чадамж, Хөдөлгөөний чадамж, Хөгжмийн чадамж, Зурах, урлах, Эрүүл мэндийн мэдлэг, зан үйл, Хувь хүний чадамж болон Математикийн чадамжид оноосон. Хөгжлийн чиглэл бүрээр асуултуудын арифметик дундажийг гаргасан. Эдгээр дундаж нь 1-ээс 5-ын хоорондох үзүүлэлттэй байна.

Мэдээллийн шинжилгээг "psych" Revelle, W. (2019) psych: Хувь хүний болон сэтгэлзүйн судалгааны аргачлал (R 3.6.2, R Core Team. 2019)-ын тусламжтайгаар хийсэн.


4. Үр дүн

2015 онд явуулсан анхны судалгаагаар хөвгүүд болон охидын хооронд ялгаа байгаа эсэхийг тодруулж, ажиглалтын хуудасны чанарыг шалгасан. Хөгжлийн чиглэл бүрийн дундаж, хүчин зүйлсийн бүтцээс харахад хүйсийн хооронд мэдэгдэхүйц ялгаа илрээгүй тул энэ хүчин зүйлийг цаашид нарийвчлан авч үзээгүй.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хот, хөдөөгийн сургуулийн өмнөх байгууллагуудын хооронд мэдэгдэхүйц ялгаа байсан бөгөөд энэ хүчин зүйлийн үзүүлэлт дараагийн судалгаануудаар мөн баталгаажсан (Зураг 4.1)². Бүх чиглэлээр хөдөөгийн цэцэрлэгийн хүүхдүүд хотын цэцэрлэгийн хүүхдүүдээс илүү сайн үзүүлэлттэй байсан.


² Зураг 4.1-д Ажиглалтын хуудас дахь хөгжлийн чиглэл тус бүрийн дэд хэсгүүдээр хөдөөгийн хүүхдийн хөгжлийн үзүүлэлт хотын хүүхдийнхээс хэр зэрэг илүү байсан (0.00-0.25)-ыг харуулав.

Зураг 4.1 Хот, хөдөөгийн ялгаа



2016 оноос эхлэн бүх аймгийн төлөөлөл болсон хүүхдүүдийн хөгжилд ахиц гарсан. Хоёр тодорхой үр дүн харагдсан: (1) 2016-2018 онд бүх хөгжлийн чиглэлээр ажигласан чадамжууд тогтмол илт өссөн үзүүлэлттэй байсан, (2) хөгжлийн чиглэл бүрийг авч үзэхэд зарим нь хоорондоо хөгжлийн түвшнээр эрс ялгаатай байв (Зураг 4.2). Ажигласан чадамжуудаас эрүүл мэндийн мэдлэг, зан үйл болон хувийн чадамж маш сайн, сайн үзүүлэлттэй байхад хөдөлгөөний чадамж илт доогуур байсан. Дундаж хэсэгт хөгжмийн чадамж, хэл ярианы чадамж орж байв. Доогуур хэсэгт математик болон дүрслэх урлагийн чадамжууд багтсан.

Зураг 4.2 2016 -2018 оны нэгдсэн үзүүлэлт



2017, 2018 онд оршин суугаа газар нутаг зэрэг нийгэм-хүн ам зүй (социодемограф)-н мэдээллээс гадна цэцэрлэгийн үүсгэн байгуулагч (улсын,


хувийн) болон байгууллагын дижитал тоног төхөөрөмжийн талаар мэдээлэл цуглуулсан.

Хот, хөдөөгийн цэцэрлэгүүдийг харьцуулахад хөдөөгийн цэцэрлэгүүдийн үзүүлэлт бага зэргийн өсөлттэй гарсан бөгөөд хотын цэцэрлэгүүдийн өсөлттэй харьцуулахад ялгаа нь мэдэгдэхүйц бага байсан (Зураг 4.3).


Хөгжлийн чиглэл тус бүрийн хөгжлийн явцын ялгаа (Differences in expression) бол өөрчлөлтгүй байв.

Хөдөөг тухайн оршин буй газар нутгийн хэмжээгээр нь ялган авч үзэхэд маш сонирхолтой дүр зураг харагдана (Зураг 4.4). Хөдөөгийн хамгийн жижиг нэгжүүдэд хамгийн их эерэг өсөлт гарсан байв. 2017 онд жижиг нэгжүүдийн үзүүлэлтийг хотынхтой харьцуулахад ойр байсан бол 2018 оны харьцуулалтаар бүх хөгжлийн чиглэлээр өндөр үзүүлэлт харуулсан. Мөн хөдөөгийн томоохон нэгжүүдийн үзүүлэлт бараг хэвээрээ байсан бол хотын сургуулийн өмнөх байгууллагуудынх хөгжлийн бүх чиглэлээр мэдэгдэхүйц өссөн дүнтэй байв.

Зураг 4.3 Хот, хөдөөгийн хүүхдүүд




Зураг 4.4 Оршин суугаа газар нутгийн хэмжээгээр




Ажиглалтад хамрагдсан хүүхдүүдийн хөгжлийн ялгааг мөн бус нутаг буюу аймгуудаар нь авч үзсэн болно (Зураг 4.5 ба 4.6).

Зураг 4.5 Аймаг, дүүрэг 2017 онд



Зураг 4.6 Аймаг, дүүрэг 2018 онд



Аймгуудын хооронд мэдэгдэхүйц ялгаанууд гарсан. Гэхдээ 2017 оныг 2018 онтой харьцуулахад хөгжлийн эерэг байдал харагдана. Ихэнх аймаг хөгжлийн бүх чиглэлээр эерэг хандлагатай байсан. Харин нэг аймагт хөгжлийн сөрөг байдал тодорхой ажиглагдсан.

Дараах гурван жишээг харуулъя.

Зураг 4.7: 2017-оос 2018 онд хөгжлийн бүх бүрэлдэхүүн хэсгээр тодорхой өсөлт харуулсан аймаг


Зураг 4.8: Хөгжил нь бараг өөрчлөгдөөгүй

Зураг 4.9: Ажигласан чадамжууд сөрөг байсан нэг жишээ, өөрөөр хэлбэл үзүүлэлтүүд нь муудсан аймаг.


Зураг 4.7 Дундговь аймаг




Зураг 4.8 Увс аймаг



Зураг 4.9 Баянхонгор аймаг



Улсын болон хувийн цэцэрлэгүүдийн хооронд мөн ялгаа харагдсан (Зураг 4.10). 2017 онд хувийн цэцэрлэгүүдэд өөрчлөлт бараг байхгүй байсан бол 2018 онд мэдэгдэхүйц ялгаа гарч ирсэн. Энэ нь үзүүлэлтүүдийн өсөлт мөн хөгжлийн чиглэлүүдийн хоорондох зайнд аль алинд нь харагдсан.

Зураг 4.10 Улсын болон хувийн цэцэрлэг

Институтчилэгдсэн боловсрол мөн албан бус боловсролд дижитал мэдээллийн хэрэгсэл, ялангуяа интернэтэд нэвтрэх асуудал улам чухал болж байна. Тиймээс цэцэрлэг ямар хэрэгслээр нэвтрэх мэдээлэлд хүрч байгаа нь маш чухал. Үүнтэй холбоотойгоор сүлжээнд нэвтрэх хэрэгслийн чанар нь сурган хүмүүжүүлэгчдийн сургалт, хүмүүжлийн ажилд, улмаар хүүхэд чадамж эзэмшихэд шууд болон шууд бусаар нөлөөлдөг уу гэсэн асуулт гарч ирдэг.

Үүнтэй холбогдуулан интернэтэд нэвтрэх техник хэрэгсэл (LAN³-тухайн хэсэг дэх сүлжээ), Modem⁴, Wifi⁵, 3G/4G⁶, интернэтийн сүлжээгүй)-ийг цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн түвшинтэй уялдуулан авч үзэхэд сонирхолтой дүр зураг харагдсан (Зураг. 4.11). 2017 онд хүүхдийн хөгжлийн түвшинд хөгжлийн чиглэл бүрээр маш бага ялгаа харагдсан. Зөвхөн LAN холболттой байгууллагуудад л үзүүлэлт нь бууралттай байв. 2018 онд энэ дүр зураг мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Шинэ технологиор интернэтэд холбогдсон цэцэрлэгийн чадамжийн үзүүлэлт ажигласан бүх хөгжлийн чиглэлээр тодорхой харагдахуйц өсөлттэй байв. Интернэтэд холбогдох сүлжээгүй байгууллагуудад чадамжийн өсөлт нь багассан байсан. Мөн Wifi-аар холбогдсон газруудад үзүүлэлт нь муудсан байв.


³ LAN - сүлжээний тооцоолол. Үүнийг жишээлбэл гэрт буюу компаниуд ашигладаг.

⁴ das **Modem** (**Mod**ulator ба **Dem**odulator-аас) хоёр дижитал төхөөрөмжийн төгсгөлийн хооронд дижитал дохио солилцох мэдээллийн хэрэгсэл.

⁵ WiFi: IEEE-802.11-стандартад суурилсан, бусад WiFi-хэрэгслүүдтэй нийцсэн утасгүй сүлжээ. WiFi бүр WLAN. WLAN: Төвлөрсөн бус утасгүй сүлжээ. Энэ сүлжээний стандартыг нарийвчлан заагаагүй байдаг.

⁶ 3G / 4G – Үүрэн холбооны стандартын тодорхойлолт (3G: 3 дахь үе, 4G: 4 дэх үе)

Зураг 4.11 Дижитал мэдээлэлд холбогдох сүлжээ



5. Үр дүнгийн дүгнэлт

Эхний судалгаагаар илрүүлсэн хүчин зүйлсийн бүтэц нь ажиглалтын аргачлалын үнэн зөв эсэхийг шалгах факторын анализаар жил бүр баталгаажиж байв. Хүчин зүйлүүд нь хүүхдийн хөгжилтэй холбогдуулан ажигласан чадамж бүрийг сайн тусгасан байв. Ажиглалтын аргачлал нь *enlightened variance*-аар 82%-тай байсан нь маш сайн үнэлгээг харуулсан. Найдвартай байдал (Reliability) нь кронбахс альфа (Cronbachs Alpha)-гаар .9-ээс дээш үнэлгээтэй байгаа нь маш сайн. Үүгээрээ 3-аас 6 насны цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийг ажиглах ажиглалтын хуудас нь шинжлэх ухааны судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлж, хэрэгсэл нь болж өгсөн.

Ажиглалтын хуудсыг боловсруулж эхний судалгаа авснаас хойш хөгжлийн бүхий л чиглэлээр үр дүн нь тасралтгүй сайжирч ирсэн бөгөөд үүнд хөвгүүд, охидын хооронд ялгаа байхгүй нь тогтоогдов.

Бүх судалгааны үр дүнгээр Эрүүл мэндийн мэдлэг, зан үйл хамгийн сайн үзүүлэлттэй нь илт тодорхой, дараа нь Хувийн чадамж орж байв. Хэлний болон Хөгжмийн чадамж дундаж зэрэгт тэдгээрийн дараа математикийн чадамж орж байлаа. Зурах, урлан бүтээх үйлийн үзүүлэлт дундаас арай доогуур байв. Хамгийн бага үзүүлэлтийг байнга хөдөлгөөний чадамж үзүүлсээр ирэв.

Чадамж тус бүрийн хөгжил ихэнхдээ зэрэгцээ (параллель) явагдаж байв. Гэсэн хэдий ч аймаг тус бүр, хот, хөдөө, улсын болон хувийн байгууллагууд, мэдээллийн сүлжээнд холбогдсон байдал зэргээрээ зарим илт ялгаанууд гарч

байв. Энэ нь жил тутмын үр дүнгээс гадна мөн 2017-2018 оны хоорондох өөрчлөлтийн үзүүлэлтээс харагдаж байлаа.

2015-аас 2018 онд *enlightened variance* тогтмол өссөн нь нэгдүгээрт, СӨБ-ын сургалтын хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн чиглэлүүд болон чадамжуудыг үнэлэхэд зориулан боловсруулсан ажиглалтын аргачлал тохиромжтой байгаа, хоёрдугаарт, багш нарын ажиглах чадамж нэмэгдсэнийг харуулж байна. Багшийн ажиглах чадамж бол хүүхэд бүрийн хөгжилд нь тохирсон туслалцаа, түлхэц үзүүлэх чухал нөхцөл юм.

Бүх хүүхэд бүх чадамжаараа ажиглагдахуйц ахисан үзүүлэлттэй үнэлэгдсэн нь цэцэрлэгт багш нар хүүхдийн хөгжлийг дэмжиж, хөгжилд нь түлхэц үзүүлэхэд монголын СӨБ-ын сургалтын хөтөлбөр хийгээд түүний хэрэгжилт зохицсон болохыг харуулж байна.

Ном зүй

- R 3.6.2, R Core Team (2019). R: A language and environment for statistical computing. R Foundation for Statistical Computing, Vienna, Austria. URL <https://www.R-project.org/>.
- using “psych” Revelle, W. (2019) psych: Procedures for Personality and Psychological Research, Northwestern University, Evanston, Illinois, USA, <https://CRAN.R-project.org/package=psych>
- Bühner, M. (2011). Einführung in die Test- und Fragebogenkonstruktion (3. Auflage). München: Pearson.
- Fröhlich-Gildhoff, K. (2013). Angewandte Entwicklungspsychologie der Kindheit. Stuttgart: Kohlhammer.
- KOMPIK, 2014, Gütersloh: Bertelsmann; 2019, München: Staatsinstitut für Frühpädagogik
- Law on Preschool Education, Parliament of Mongolia, 2008, revised by the meeting of April 14, 2016
- Mayr, T. (2012) Entwicklungsbegleitende Beobachtung - Grundlage für eine Individualisierung frühkindlicher Bildung. München: Staatsinstitut für Frühpädagogik.
- Sylva, K., Melhuish, E., Sammons, P., Siray-Blatchford, I. & Taggart, B. (2004). The Effective Provision of Pre-School Education (EPPE) Project: Final Report. A longitudinal Study Funded by the DfES 1997-2004: Evidence & research.
- Tabachnik, B. G., & Fidell, L. S.(2013). Using multivariate statistics. (6th edition). Boston: Pearson.
- Viernickel, S. & Völkel, P. (2005). Beobachten und dokumentieren im pädagogischen Alltag. Freiburg, Breisgau 2005

Герман хэлнээс орчуулсан: Н.Норжхорлоо (Ph.D)

Children in Mongolian Kindergartens Investigation of the Level of Development of Kindergarten Children

Bernhard Nagel, Erik Danay
Bavarian State Institute of Early Childhood Research, Germany
Corresponding author: bernhard.Nagel@extern.lrz-muenchen.de

Received: 6/03/2020/

Revised: 10/20/2020

Accepted: 10/30/2020

Abstract

In 2016 a new education and training plan was introduced in Mongolia. Part of this plan is to observe each kindergarten child once in every kindergarten year with regard to his or her stage of development and to document the observation. This observation is carried out using a structured and standardized observation procedure. Structured observation procedures for child development are suitable for making valid and reliable statements on the development of a very large number of children in an economic way. This is an important prerequisite for investigating the connection between educational policy measures and the developmental progress of children.

In the years 2016 to 2018, the development data of a representative sample of 15,000 kindergarten children (corresponding to almost 20 percent of the corresponding total population) were subjected to a study.

The results show significant increases in developmental status in the individual developmental areas from 2016 to 2018. Differences according to criteria such as city/country, private/state, availability of digital media could also be identified. There are clear differences in the comparison of the individual Aimags or the individual districts of Ulaanbaatar

Keywords

Observation of the development of children of all ages, level of development, support of the children's development, observation sheet, observation questionnaire

